



ИНД-108

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-108 нь 10, эсхүл түүнээс дээш зорчигчийн суудалтайгаар гэрчилгээжсэн агаарын хөлгөөр, Монгол Улсаас болон Монгол Улсад тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ эрхэлж буй агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь, ИНД-119 (агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч) болон ИНД-129 (гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч)-ийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлтийн хүрээнд, агаарын тээвэрлэгчээс энэ дүрэмд заасан аюулгүйн хамгаалалтын тусгай шаардлагуудыг агуулсан Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр боловсруулах болон хэрэгжүүлэхийг шаардана.

Олон улсын агаарын тээвэрлэгчид тавигдах аюулгүйн хамгаалалтын шаардлага нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт болон зөвлөмжид нийцсэн байна.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-108-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-108, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2003 оны 03 сарын 12

Нэмэлт, өөрчлөлт 1

2008 оны 12 сарын 09

Нэмэлт, өөрчлөлт 2

2011 оны 10 сарын 14

Нэмэлт, өөрчлөлт 3 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-108-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 108 A.11-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг — Ерөнхий зүйл.....	5
108.1. Хамрах хүрээ.....	5
108.3. Нөөц.....	5
В Бүлэг — Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлага	5
108.51. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр	5
108.53. Аюулгүйн хамгаалалтын шаардлага – Орон нутаг	5
108.55. Аюулгүйн хамгаалалтын шаардлага – Олон улс	7
108.57. Нислэгт олгох аюулгүйн хамгаалалтын зөвшөөрөл	11
108.59. Ажилтнуудын сургалт	11
108.60. Бүртгэл	12
108.61. Зөрчлийг мэдээлэх	12
108.63. Аюулгүйн үзлэг	12

А Бүлэг — Ерөнхий зүйл

108.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь ИНД-119 болон ИНД-129-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн зохицуулалтын шаардлагыг тогтооно.

108.3. Нөөц

В Бүлэг — Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлага

108.51. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр

Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь дараах мэдээллийг агуулна:

- (1) агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн хэрэгжүүлэлттэй холбоотой аливаа ажлыг бусад байгууллагаар гүйцэтгүүлэхээр зорьж байгаа бол, тухайн гэрээлэгч, эсхүл бусад байгууллагыг өөрийн агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлагыг хангаж байгааг бататгах гэрээний нөхцөлийг;
- (2) 108.59-д шаардсан журмын дагуу, ажилтнуудын сургалт хариуцсан тухайн этгээдийн дэлгэрэнгүйг;
- (3) дараах зүйлээр шаардсан журмын дэлгэрэнгүйг:
 - (i) 108.53 - орон нутгийн аюулгүйн хамгаалалтын шаардлагын талаар;
 - (ii) 108.55 - олон улсын аюулгүйн хамгаалалтын шаардлагын талаар;
 - (iii) 108.57 - нислэгт олгох зөвшөөрлийн талаар;
 - (iv) 108.59 - ажилтнуудын сургалтын талаар;
 - (v) 108.61 - зөрчлийг мэдээлэх болон тайлагнах талаар.

108.53. Аюулгүйн хамгаалалтын шаардлага – Орон нутаг

(a) Орон нутгийн зорчигч тээврийн тогтмол нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь Монгол Улсын дотор хийгдэж буй нислэгийн зорчигчид, багийн гишүүд, газрын ажилтнууд, агаарын хөлөг болон байгууламжийг хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүйн хамгаалалтын журамтай байх ёстой.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын журам нь дараах арга хэмжээг тогтоох ёстой:

- (1) ИНД-91.9-ийн шаардлагыг хангасан агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх;

- (2) хэрэв агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгийн заналхийлэл, эсхүл хууль бус үйлдлийн аливаа бусад заналхийлэл бий болсон тохиолдолд, агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын ажилтанд учрах аюулыг багасгах;
- (3) тухайн агаарын хөлгийг хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор агаарын тээвэрлэгчийн хяналтгүй орхисон агаарын хөлөгт нэвтрэх үйл ажиллагаанд байнга хяналт тавих;
- (4) Монгол Улсын аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалтын бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалтын бүс болон аливаа бусад аэродромын үйл ажиллагааны бүсэд агаарын тээвэрлэгчийн байгууламжаар дамжин нэвтрэх, эсхүл агаарын тээвэрлэгчийн зорчигч, ажилтнууд, тээш, ачаа, шуудангийн илгээмж, эсхүл агаарын хөлгийн хангалтад ашигладаг аливаа бусад хаалгаар дамжин нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих;
- (5) тухайн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр зорьж буй тээш, ачаа, илгээмж болон шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын тээвэрлэгчийн хангалтад зохих аюулгүйн хамгаалалтын үзлэг шалгалт хийх;
- (6) хэрэв тухайн агаарын хөлгийн бүхээгт хуулийн дагуу саатуулагдсан, эсхүл хууль хяналтын байгууллагын журмаар аялахыг шаардсан нэг, эсхүл түүнээс дээш этгээдийг тээвэрлэх тохиолдолд, тэднийг харгалзагчтай байхыг шаардсан эсэхээс үл хамааран, нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангаж, тухайн хөлгийн даргад мэдэгдэх;
- (7) хэрэв зорчигч тухайн агаарын хөлөгт суугаагүй бол, агаарын тээвэрлэгч болон хөлгийн дарга эрсдэлийг үнэлж, агаарын хөлөгт байгаа тухайн зорчигчийн тээшийг тээвэрлэх эсэхийг шийдэх;
- (8) хэрэв Сайд, эсхүл Дарга, хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт авч орохоос сэргийлэх зорилгоор бүх зорчигч, багийн гишүүд болон зорчигч, багийн гишүүдийн гар тээшинд аюулгүйн үзлэг хийхийг шаардсан бол, тэдгээрийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт орохын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;
- (9) хэрэв Сайд, эсхүл Дарга, хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачигдахаас сэргийлэх зорилгоор, гар тээшнээс бусад бүх тээшинд аюулгүйн үзлэг хийхийг шаардсан бол, тэдгээрийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;
- (10) хэрэв Дарга, агаарын хөлөгт байгаа этгээд, эсхүл агаарын хөлөг, эсхүл аэродромд учрах аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэнийг илрүүлсэн, эсхүл сэжиглэж байгаа бөгөөд энэ нь тухайн орон нутгийн нислэгийн үйл ажиллагаанд хамгаалалтын нэмэлт арга хэмжээг шаардаж байгаа бол, агаарын тээвэрлэгчийн үйлчилгээний аюулгүйн хамгаалалтыг сайжруулах хамгаалалтын түр арга хэмжээг авах;

(11) нислэгийн үед агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх.

(с) Энэ зүйлийн (b)(6)-д шаардсан журам нь, тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний нислэгээр хуулийн дагуу саатуулагдсан этгээдийг тээвэрлэхтэй холбоотой дараах нөхцөлийг бататгах журмыг багтаасан байх ёстой:

- (1) тухайн этгээд нь харгалзагчтай байх;
- (2) тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болох аливаа эд зүйл авч яваагүй болохыг харгалзагч нь бататгах;
- (3) харгалзагч нь, тухайн этгээдийн үйлдлийг хязгаарлахад тохирох хэрэгслээр тоноглогдсон байх;
- (4) тухайн этгээдийн суудлын байрлал болон аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын талаар хөлгийн дарга болон бүхээгийн ахлах ажилтанд мэдэгдэх;
- (5) тухайн этгээд, түүний харгалзагчид согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх;
- (6) тухайн этгээдийн хэрэглээнд метал хэрэгсэл ашиглахгүй байх;
- (7) тухайн этгээдийг ослын гарцны зэргэлдээх суудалд, эсхүл эгнээнд суулгахгүй байх;
- (8) тухайн нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн суудалд тухайн этгээдийг суулгах;
- (9) гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамж нь 29, эсхүл түүнээс цөөн суудалтай агаарын хөлөгт 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг тээвэрлэх ба гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжийн нэмэлт 25 суудал бүрт 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг нэмж тээвэрлэх.

108.55. Аюулгүйн хамгаалалтын шаардлага – Олон улс

(a) Олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь Монгол Улсад, эсхүл Монгол Улсаас хийгдэж буй нислэгийн зорчигчид, багийн гишүүд, газрын ажилтнууд, агаарын хөлөг болон байгууламжийг хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүйн хамгаалалтын журамтай байх ёстой.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын журамд дараах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар заасан байх ёстой:

- (1) ИНД-91.9-ийн шаардлагыг хангасан агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх;
- (2) хэрэв агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгийн заналхийлэл, эсхүл хууль бус үйлдлийн аливаа бусад заналхийлэл бий болсон тохиолдолд, агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын ажилтанд учрах аюулыг багасгах;

- (3) агаарын тээвэрлэгчийн хяналтгүй орхисон агаарын хөлгийг хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор тухайн агаарын хөлөгт нэвтрэх үйл ажиллагаанд байнгын хяналт тавих;
- (4) Монгол Улсын аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалтын бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалтын бүс болон аливаа бусад аэродромын үйл ажиллагааны бүсэд агаарын тээвэрлэгчийн байгууламжаар дамжин нэвтрэх, эсхүл агаарын тээвэрлэгчийн зорчигч, ажилтнууд, тээш, ачаа, шуудангийн илгээмж, эсхүл агаарын хөлгийн хангалтад ашигладаг аливаа бусад хаалгаар дамжин нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих;
- (5) хэрэв Дарга, агаарын хөлөгт байгаа этгээд, эсхүл агаарын хөлөг, эсхүл аэродромд учрах аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэнийг илрүүлсэн, эсхүл сэжиглэж байгаа бөгөөд энэ нь аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ авахыг шаардаж байгаа бол, Монгол Улсад, эсхүл Монгол Улсаас нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгчийн үйлчилгээний аюулгүйн хамгаалалтыг сайжруулах аюулгүйн хамгаалалтын түр арга хэмжээг хэрэгжүүлэх;
- (6) энэ зүйлийн (с)-г харгалзан, агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр зорьж буй тээш, ачаа, илгээмж болон шууданд зохих аюулгүйн хамгаалалтын үзлэг шалгалт хийх;
- (7) хэрэв тухайн агаарын хөлгийн бүхээгт хуулийн дагуу саатуулагдсан, эсхүл хууль хяналтын байгууллагын журмаар аялахыг шаардсан нэг, эсхүл түүнээс дээш этгээдийг тээвэрлэх тохиолдолд, тэднийг харгалзагчтай байхыг шаардсан эсэхээс үл хамааран, нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангаж, тухайн хөлгийн даргад мэдэгдсэн байх;
- (8) агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт зорчигч зөвшөөрөлгүй эд зүйл авч орохоос сэргийлж дамжин өнгөрөх, эсхүл шилжин суух зорчигч болон зорчигчийн гар тээшинд хяналт тавих;
- (9) дараахаас бусад тохиолдолд, дамжин өнгөрөх нислэгээс буусан зорчигч бүхээгт авч ороод үлдээсэн эд зүйлийг агаарын хөлгөөс буулгах, эсхүл тухайн нислэг эхлэхийн өмнө бусад арга хэмжээг зохих хэлбэрээр авах:
 - (i) тухайн нислэг эхэлсэн Улсын, зорчигчийн аюулгүйн үзлэгийн ажиллагаа нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц бол; эсхүл
 - (ii) тухайн нислэг нь хуваарьт бус буулт хийж байгаа бол.
- (10) агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт тээвэрлэхээр аэродром дотор шилжүүлэн зөөвөрлөх тээш, ачаа, шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын тээвэрлэгчийн хангалтад зохих аюулгүйн хамгаалалтын хяналт шалгалт хийх;
- (11) ачаа, эсхүл шуудангаас бусад, гэхдээ агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр зорьж буй илгээх барааны баглаа боодол бүрт (дагалдаагүй, эсхүл арилжааны буухиа хүргэлтийн үйлчилгээ ашиглаж байгаагаас үл хамааран) аюулгүйн үзлэг хийх;

- (12) хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт авч орохоос сэргийлэх зорилгоор бүх зорчигч, багийн гишүүд болон зорчигч, багийн гишүүдийн гар тээшинд, тэдгээрийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт орохын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;
- (13) агаарын хөлөгт суугаагүй зорчигчийн тээшийг энэ зүйлийн 17-д шаардсаны дагуу тээвэрлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд, тээвэрлэхээс сэргийлэх;
- (14) нислэг нь тухайн цэгээс эхлэлтэй агаарын хөлөгт, хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг нууж болох аливаа сэжигтэй зүйл, эсхүл хэвийн бус байдлыг илрүүлэх журмыг багтаасан нислэгийн өмнөх үзлэг хийх;
- (15) хэрэв нисэх буудлын бүртгэлийн цэгээс өөр газраас эхлэлтэй тээшийг зорчигчийн нислэгээр тээвэрлэх бол, тухайн бүртгэсэн цэгээс агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт байрлуулах хүртэл тээшинд аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;
- (16) энэ зүйлийн (h)-д зааснаас бусад тохиолдолд, хууль бус үйлдэлд ашиглаж болох зэвсэг, тэсрэх зүйл, эсхүл бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихаас сэргийлэх зорилгоор, гар тээшнээс бусад, тээшин дэх бүх эд зүйлийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;
- (17) зөвхөн тухайн агаарын тээвэрлэгчийн зөвшөөрсөн тээшийг тээвэрлэх;
- (18) нислэгийн үед агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх.
- (c) Агаарын тээвэрлэгч дараахаас бусад тохиолдолд, зорчигч тээвэрлэж буй агаарын хөлөгт ачаа, эсхүл шуудан ачихыг зөвшөөрөхийг хориглоно:
- (1) тухайн ачаа, эсхүл шууданг Зохицуулалттай агаарын ачааны байгууллага (цаашид ЗААБ гэх)-аас хүлээн авсан байх ба тухайн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд:
- (i) ЗААБ-аас олгосон аюулгүйн хамгаалалтын мэдэгдэл дагалдсан;
- (ii) тухайн илгээх бараанд гэмтэл учруулаагүй болохыг бататгах шалгалтыг агаарын тээвэрлэгч хийсэн, эсхүл
- (2) хэрэв агаарын тээвэрлэгч нь ЗААБ биш этгээдээс ачаа, эсхүл шуудан хүлээн авахыг зөвшөөрсөн бол тухайн ачаа, эсхүл шууданд энэ зүйлийн (d)-д заасны дагуу зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавьсан, эсхүл
- (3) энэ хэсгийн (1) болон (2)-т заасныг үл харгалзан, хэрэв тухайн ачаа, эсхүл шууданд Сайд, эсхүл Даргаас аюулгүйн үзлэг хийх чиглэл өгсөн бол, тухайн ачаа, эсхүл шууданд өгсөн чиглэлийн дагуу аюулгүйн үзлэг хийж, аюулгүй хэлбэрээр хадгалсан.
- (d) Хэрэв агаарын тээвэрлэгч нь ЗААБ биш этгээдээс ачаа, эсхүл шууданг хүлээн авахыг зөвшөөрсөн бол, тухайн агаарын тээвэрлэгч энэ зүйлийн (c)(2)-т шаардсан

аюулгүйн хамгаалалтын хяналт нь ИНД-109-ийн шаардлагыг хангаж байгааг бататгах зорилгоор, дараах дүрмээр шаардсантай дүйцэх зохих байгууламж болон журамтай байх үүрэгтэй:

- (1) ИНД-109.53 – байгууламжийн шаардлага;
- (2) ИНД-109.55 – ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журам;
- (3) ИНД-109.57 – аюулгүйн үзлэгийн журам;
- (4) ИНД-109.59 – зөвшөөрөл олгох журам;
- (5) ИНД-109.61 – тогтмол харилцагчийн бүртгэл болон журам;
- (6) ИНД-109.63 – ажилтнуудын сургалт;
- (7) ИНД-109.65 – ачаа болон аюулгүйн хамгаалалтын зөрчил;
- (8) ИНД-109.67 – бүртгэл.

(е) Энэ зүйлийн (d)-д шаардсан байгууламж болон журмын дэлгэрэнгүй нь ИНД-119, эсхүл ИНД-129-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт багтсан байх ёстой.

(f) Энэ зүйлийн (b)(7)-д шаардсан журам нь тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний нислэгээр хуулийн дагуу саатуулагдсан этгээдийг тээвэрлэхтэй холбоотой дараах шаардлагыг бататгах журмыг агуулсан байх ёстой:

- (1) тухайн этгээд нь харгалзагчтай байх;
- (2) тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болох аливаа эд зүйл авч яваагүй болохыг харгалзагч нь бататгах;
- (3) харгалзагч нь тухайн этгээдийн үйлдлийг хязгаарлахад тохирох хэрэгсэлтэй байх;
- (4) тухайн этгээдийн байрлал болон аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын талаар хөлгийн дарга болон бүхээгийн ахлах ажилтанд мэдэгдэх;
- (5) тухайн этгээд, түүний харгалзагчид согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх;
- (6) тухайн этгээдийн хэрэглээнд метал хэрэгсэл ашиглахгүй байх;
- (7) тухайн этгээдийг ослын гарцны зэргэлдээх суудалд, эсхүл эгнээнд суулгахгүй байх;
- (8) тухайн нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн суудалд тухайн этгээдийг суулгах;
- (9) гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамж нь 29, эсхүл түүнээс цөөн суудалтай агаарын хөлөгт 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг тээвэрлэх ба гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжийн нэмэлт 25 суудал бүрт 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг нэмж тээвэрлэх.

(g) Хэрэв орон нутгийн агаарын тээвэрлэгч нь олон улсын агаарын тээвэрлэгчийн нэрийн өмнөөс, эсхүл олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний дамжуулан тээвэрлэлтэд зориулан зорчигч, эсхүл тээшний бүртгэл гүйцэтгэх бол,

орон нутгийн агаарын тээвэрлэгч нь олон улсын агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг мөрдөхийг олон улсын агаарын тээвэрлэгч бататгах үүрэгтэй.

(h) Сайд, эсхүл Дарга тухайн тээшинд аюулгүйн үзлэг хийсэн байхыг шаардсанаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (b)(16) нь олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах тээшинд хамаарахгүй.

(i) Энэ зүйлийн (c)(1) болон (2)-ын шаардлага нь:

(1) илгээж буй дипломат байгууллагын албан ёсны гарын үсэг бүхий албан тоот дагалдсан, түүний шинж чанарыг таних гадна тэмдэглэгээтэй, дипломат сав боодолд зөөгдөж буй дипломат шууданд; эсхүл

(2) олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах ачаа, эсхүл шууданд хамаарахгүй.

108.57. Нислэгт олгох аюулгүйн хамгаалалтын зөвшөөрөл

Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь, агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй агаарын хөлөгт Монгол Улсын аливаа аэродромоос нисэн гарах зөвшөөрөл өгөхөөс өмнө тухайн нислэгт хамааралтай аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг дагаж мөрдсөнийг бататгах журамтай байна.

108.59. Ажилтнуудын сургалт

(a) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь дараах шаардлагыг бататгах журамтай байх ёстой:

(1) аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт дэлгэрэнгүй заасан аюулгүйн хамгаалалтын журмыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтнууд нь үүргээ чадварлагаар гүйцэтгэхэд хангалттай хэмжээнд суралцсан байх;

(2) тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээ болон бусад үйлчилгээнд ажиллаж байгаа бусад бүх ажилтнууд нь агаарын тээвэрлэгч болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын талаар үндсэн мэдлэгтэй байх;

(3) сургалтыг агаарын тээвэрлэгчээс зөвшөөрөгдсөн этгээдийн удирдан зохион байгуулсан хэлбэрээр гүйцэтгэсэн байх;

(4) сургалтад хамрагдсан байхыг шаардсан этгээд бүр нь сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын хэсэгт 3 жилээс ихгүй давтамжтай хамрагдах.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах зүйлийг агуулсан байх ёстой:

(1) анхан шатны сургалт болон давтан сургалтын холбогдох хэсгүүд;

(2) тухайн хийгдсэн сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл ур чадварын үнэлгээ;

(3) холбогдох аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг тус бүрийн сургалтын хөтөлбөрийн задаргаа.

108.60. Бүртгэл

(а) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь, 108.59-ийн дагуу сургагдсан байхыг шаардсан этгээд бүрийн нягт нямбай бүртгэлийг хөтлөхөд шаардлагатай, бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах дараах дэлгэрэнгүйг багтаасан журамтай байх ёстой:

- (1) хийсэн сургалтын хэсэг бүрийн;
- (2) хийсэн сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл ур чадварын үнэлгээний.

108.61. Зөрчлийг мэдээлэх

Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь тухайн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгтэй холбоотой аюулгүйн хамгаалалтын зөрчлийн талаар ИНД-12-ийн дагуу Даргад мэдээлэх болон шаардлагатай бол, тайлагнах журамтай байна.

108.63. Аюулгүйн үзлэг

Энэ дүрмийн 108.53 болон 108.55-д шаардсан зорчигч, багийн гишүүд болон тээшний аюулгүйн үзлэгийг дараах байгууллага гүйцэтгэх ёстой:

- (1) Монгол Улсаас, эсхүл Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгийн хувьд, ИНД-140-ийн дагуу олгосон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;
- (2) Монгол Улсын гаднах аэродромоос үйл ажиллагаанд оролцож буй Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн хувьд, нисэн гарах тухайн улсын зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн аюулгүйн үзлэг хийх байгууллага.

--oOo--